

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2017-2018 ОНЫ  
ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН  
ТАНИЛЦУУЛГА**

**1. Дээд боловсролын сургалтын байгууллага (ангилал, байршил, өмчийн хэлбэр)**

**1.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо.**

2017-2018 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр Монгол Улсад дээд боловсролын 96<sup>1</sup> байгууллага статистикийн мэдээнд хамрагдаж сургалтын үйл ажиллагаа явуулж байнагэсэн мэдээ өгсөн байна(Хүснэгт 1).

Хүснэгт 1. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо

<b>Дээд боловсролын сургалтын байгууллага</b>				
	Бүгд	Төрийн	Төрийн бус	Гадаадын салбар сургууль
<b>2013-2014</b>	<b>100</b>	16	79	5
<b>2014-2015</b>	<b>101</b>	16	80	5
<b>2015-2016</b>	<b>100</b>	17	78	5
<b>2016-2017</b>	<b>95</b>	17	74	4
<b>2017-2018</b>	<b>96</b>	18	75	3

Дээдболовсролын сургалтын байгууллагын тоо өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 1-ээр буюу ойролцоогоор 1.1 хувиар өссөн байна. Энэ нь дараах өөрчлөлтүүдтэй холбоотой юм. Үүнд:

i) Төрийн өмчийн сургуулийн хувьд шинээр Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нэмэгдсэн

ii) Төрийн бус өмчийн сургуулиудын хувьд: Ажил олгогчдын эздийн академи дээд сургууль, Азийн боловсролын дээд сургууль, Дархан дээд сургууль, Шонхор дээд сургуулиуд нь 2017-2018 оны хичээлийн жилд албан ёсны статистикийн мэдээнд хамрагдаагүй, үйл ажиллагаа явуулаагүй, Хятад, Монголын хамтарсан олон улсын дээд сургууль, Зүүн хүрээ коллеж, Монголын хүний нөөцийн удирдлагын коллеж, Шинэ Монгол технологийн коллеж, Монгол Коосэн технологийн коллеж шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн;

ii) Гадаадын салбар сургуулийн хувьд: Дорнод Сибирийн Технологи, удирдлагын их сургуулийн Улаанбаатар хот дахь салбар сургууль үйл ажиллагаагаа зогсоосон байна.

**1.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал.**

Дээд боловсролын сургалтын 96 байгууллагын 36.5 хувь нь их сургууль, 54.2 хувь нь дээд сургууль, 6.3 хувь нь коллежийн ангилалд багтаж, 3.1 хувь нь гадаадын салбар сургууль байгаа бөгөөд өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад их сургуулийн тоо 4-өөр буюу 12.9 хувиар, коллежийн тоо 3-аар буюу 50.0 хувиар тус тус өсч, дээд сургуулийн тоо 5-аар буюу 9.6 хувиар, гадаадын салбар сургуулийн тоо 1-ээр буюу 33.3 хувиар тус тус буурсан байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо (ангиллаар<sup>2</sup>)

<sup>1</sup>2017-2018 оны хичээлийн жилд статистикийн мэдээнд хамрагдсан их, дээд сургуулийн тоо

<sup>2</sup>"Боловсролын тухай хууль"-ийн 15-р зүйлд Дээд боловсролын сургалтын байгууллагыг их сургууль, дээд сургууль, коллеж гэсэн ангилалтай байхаар заасан. БСШУ-ны сайдын 2004 оны 140-р тушаалаар Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг, БСШУ-ны сайдын 2004 оны 238-р тушаалаар Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг тус тус тогтоосон. БСШУ-ны сайдын 2010 оны 26-р тушаалаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам"-ыг мөрдөж байна.

<b>Дээд боловсролын сургалтын байгууллага</b>					
	Бүгд	Их сургууль	Дээд сургууль	Коллеж	Гадаадын салбар сургууль
<b>2013-2014</b>	<b>100</b>	18	62	15	5
<b>2014-2015</b>	<b>101</b>	18	70	8	5
<b>2015-2016</b>	<b>100</b>	25	64	6	5
<b>2016-2017</b>	<b>95</b>	31	57	3	4
<b>2017-2018</b>	<b>96</b>	35	52	6	3

Дотоодын төрийн өмчийн 18 сургуулийн 14 (**77.8%**) нь их сургуулийн, 4 (**22.2%**) нь дээд сургуулийн; төрийн бус өмчийн 75 сургуулийн 21 (**28.0%**) нь их сургуулийн, 48 (**64.0%**) нь дээд сургуулийн, 6 (**8.0%**) нь коллежийн ангилалд багтаж сургалтын ажил эрхэлж байна. Үүнийг өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад төрийн бус өмчийн их, дээд сургуулийн ангилалд нилээд өөрчлөлт гарчээ. Энэ нь дээр дурдсан үйл ажиллагаа явуулаагүй дээд сургуулиудаас гадна 3 сургуулийн ангилал өөрчлөгдөж их сургууль болсон. Үүнд: Идэр, Мандах бүртгэл дээд сургууль, Шинэ анагаах ухааны дээд сургуулиуд нь их сургуулийн статустай болсонтой тус тус холбоотой.

Сүүлийн 5 жилийн явцад дээд боловсролын сургалтын байгууллагын ангилалд ихээхэн өөрчлөлт гарч, энэ нь төрийн ба төрийн бус өмчийн сургуулиудад адилхан хамаарч байна. Дээрх хугацаанд их сургуулийн тоо 18-аас 35 болтлоо нэмэгдэж, эсрэгээр коллежийн тоо 19-өөс 3 болтлоо буурсан бол энэ хичээлийн жил 3-аар нэмэгдэж 6 болсон байна.

### **1.3. Дээд боловсролын сургалтын байгууллагын байршил.**

Дээд боловсролын сургалтын 96 байгууллагаас 89 нь Улаанбаатар хотод, 7 нь хөдөө орон нутагт байрлаж байгааг өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад Улаанбаатарт байрладаг сургуулиудын тоо 2-оор, Хөдөө орон нутагт байрладаг сургуулийн тоо нэгээр буурсан байна.

Хөдөө орон нутагт сургалтын ажил эрхэлдэг бие даасан 7 сургуулийн нэрийг өмчийн хэлбэрээр ангилан доорх хүснэгтэнд харуулав (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Хөдөө орон нутагт байрладаг дээд боловсролын сургалтын байгууллага

<b>Төрийн өмчийн</b>	<b>Төрийн бус өмчийн</b>	<b>Гадаадын салбар</b>
1. Ховд их сургууль (Ховд)	1. Маргад дээд сургууль (Орхон)	
2. Дорнод их сургууль (Дорнод)	2. Гурван тамир коллеж (Архангай)	
3. ХААИС-ийн харьяа Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн (Дархан-Уул)	3. Далай ван дээд сургууль (Хөвсгөл)	
	4. Худалдааны үндэсний дээд сургууль (Баянхонгор)	

Хөдөө орон нутагт салбартай сургуулиуд авч үзвэл:

төрийн өмчийн сургуулийн хувьд: Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль (3)<sup>3</sup>, Монгол Улсын их сургууль (2), Монгол Улсын Боловсролын их сургууль (2), Соёл, урлагийн их сургууль (1), Ховд их сургууль (1), Шинжлэх ухаан, технологийн их сургууль (2),

төрийн бус өмчийн сургуулийн хувьд: Хүмүүнлэгийн ухааны их сургууль (1), Мандах бүртгэл дээд сургууль (1), Этүгэн их сургууль (2), Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургууль (1) зэрэг 10 сургууль хөдөө орон нутагт өөрийн салбартай.

## 2. Дээд боловсролын сургалтын байгууллагад Монгол Улсын иргэдээс суралцагчид

### 2.1. Суралцагчдын тоо

2017-2018 оны хичээлийн жилийн эхэнд их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо 155,248 болж, өмнөх хичээлийн жилээс 1,890-ээр буюу 1.2 хувиар буурлаа (Хүснэгт 4). Суралцагчдын тоо төрийн өмчийн сургуульд 2,325-аар буюу 2.6 хувиар, төрийн бус өмчийн сургуульд 2,201-ээр буюу 3.3 хувиар, гадаадын салбар сургуульд 52-оор буюу 16.4 хувиар тус тус буурчээ.

Төрийн ба гадаадын салбар сургуулиудад суралцагчдын тоо буурсан бол төрийн бус өмчийн сургуулийн суралцагчдын тоо өссөн байна. Нийт суралцагчдын 89,473 буюу 57.6 хувь нь төрийн өмчийн, 65,628 буюу 42.3 хувь нь төрийн бус өмчийн, 147 буюу 0.1 хувь нь гадаадын салбар сургуульд сурч байна.

Хүснэгт 4. Суралцагчдын тоо (сургуулийн өмчийн хэлбэрээр)

Суралцагчид (сургуулийн өмчийн хэлбэрээр)				
	Бүгд	төрийн	төрийн бус	гадаадын салбар сургууль
<b>2013-2014</b>	<b>174,045</b>	101,855	71,689	531
<b>2014-2015</b>	<b>178,295</b>	103,650	74,233	412
<b>2015-2016</b>	<b>162,626</b>	95,033	67,276	317
<b>2016-2017</b>	<b>157,138</b>	91,798	65,075	265
<b>2017-2018</b>	<b>155,248</b>	89,473	65,628	147

Нийт суралцагчдын 88.0 хувь нь их сургуульд, 11.6 хувь нь дээд сургуульд, 0.3 хувь нь коллежид, 0.1 хувь нь гадаадын салбар сургуульд суралцаж байна (Хүснэгт 5). Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад их сургуульд суралцагчдын эзлэх хувь 3.5 пунктээр өссөн бол, дээд сургуульд суралцагчдын эзлэх хувь 3.5 пунктээр, гадаадын салбар сургуулиудад суралцагчдын тоо 0.1 пунктээр тус тус буурсан бол коллежид суралцагчдын эзлэх хувь хэвээрээ байна. Энэ нь их сургууль, дээд сургуулийн тооны өөрчлөлт, тухайлбал нилээд хэдэн дээд сургууль их сургуулийн ангилалд шилжсэнтэй холбоотой.

Хүснэгт 5. Суралцагчдын тоо (сургуулийн ангиллаар)

Суралцагчид (сургуулийн ангиллаар)					
	Бүгд	Их сургууль	Дээд сургууль	Коллеж	Гадаадын салбар сургууль
<b>2013-2014</b>	<b>174,075</b>	125,902	44,445	3,198	531
<b>2014-2015</b>	<b>178,295</b>	128,661	48,515	707	412
<b>2015-2016</b>	<b>162,626</b>	122,870	38,869	570	317
<b>2016-2017</b>	<b>157,138</b>	133,187	23,293	393	265
<b>2017-2018</b>	<b>155,248</b>	136,673	17,982	446	147

<sup>3</sup>Салбар сургуулийн тоог тэмдэглэсэн болно.

Тооны хувьд их сургуульд суралцагчид 3,486-аар, коллежид суралцагчид 53-аар тус тус өссөн бол, дээд сургуульд суралцагчид 5,311-аар, гадаадын салбар сургуульд суралцагчид 52-аар тус тус буурсан байна.

Их сургуулиудын хувьд суралцагчдын тоо төрийн өмчийн их сургуульд 1,937-оор буурч, төрийн бус өмчийн их сургуульд 5,423-аар нэмэгдсэн бол дээд сургуульд суралцагчдын тоо төрийн өмчийн сургуульд 175-аар, төрийн бус өмчийн сургуульд 5,136-аар тус тус буурчээ.

Хүснэгт 6. Суралцагчдын тоо (өмчийн хэлбэр, сургуулийн ангиллаар)

Ангилал	Нийт	Үүнээс:		Нийт нэгжид эзлэх хувь
		төрийн	төрийн бус	
<b>Бүгд</b>	<b>155,248</b>	<b>89,473</b>	<b>65,775<sup>4</sup></b>	<b>100.0</b>
Их сургууль	136,673	87,850	48,823	88.0
Дээд сургууль	17,982	1,623	16,359	11.6
Коллеж	446	-	446	0.3
Гадаадын салбар сургууль	147	-	147	0.1

Нийт суралцагчдын 144,061 буюу 92.8 хувь нь Улаанбаатар хотод, 11,186 буюу 7.2 хувь нь хөдөө орон нутгийн сургуулиудад (**салбар сургуулиуд ороод**) суралцаж байгаа нь өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад нийслэл хотод суралцагчдын тоо 377-оор өссөн бол, хөдөө орон нутгийн сургуулиудад суралцагчдын тоо 2,268-аар буурсан бөгөөд тэдгээрийн нийт дүнд эзлэх хувь өнгөрсөн оны түвшинтэй харьцуулбал нийт сурагчдын дүнд нийслэл хотод суралцагчдын эзлэх хувь өмнөх оноос 1.4 пунктээр өссөн бол, хөдөө орон нутгийнх эсрэгээрээ 1.4 пунктээр буурсан байна.

Хүснэгт 7. Суралцагчдын тоо (байршлаар)

	Суралцагчид (бүс нутгаар)					
	Бүгд	Улаанбаатар хотод	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
<b>2013-2014</b>	<b>174,075</b>	156,538	5,256	5,311	6,297	673
<b>2014-2015</b>	<b>178,295</b>	161,632	4,982	4,607	6,273	801
<b>2015-2016</b>	<b>162,626</b>	148,077	4,717	4,066	5,058	708
<b>2016-2017</b>	<b>157,138</b>	143,684	4,211	4,284	4,308	651
<b>2017-2018</b>	<b>155,248</b>	144,061	3,666	3,099	3,740	681

Хүснэгт 7 дээрх тоон үзүүлэлтээс харахад сүүлийн 4 хичээлийн жилд нийт суралцагчдын тоо 178 мянгаас 155 мянга болон буурсан байна.

**2.2. Суралцагчдын сургалтын хэлбэр ба боловсролын зэрэг**

Энэ хичээлийн жилд 96 их, дээд сургууль нь өдөр<sup>5</sup>, орой, эчнээ хэлбэрээр сургалт явуулж байна.

Хүснэгт 8. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид (сургалтын хэлбэрээр)

<sup>4</sup>Төрийн бус өмчийн сургуулийн тоонд гадаад салбар сургуулийн тоог оруулсан болно.

<sup>5</sup>“Дээд боловсролын тухай хууль”-ийн 8.1-д “Их сургууль, дээд сургууль, коллежийн сургалт нь өдөр, орой, эчнээ болон экстернат хэлбэртэй байж болно” гэж заасан.

<b>Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид</b>				
	Бүгд	өдөр	орой	эчнээ
<b>2013-2014</b>	<b>174,075</b>	156,946	4,364	12,765
<b>2014-2015</b>	<b>178,295</b>	159,368	4,669	14,258
<b>2015-2016</b>	<b>162,626</b>	143,775	4,548	14,303
<b>2016-2017</b>	<b>157,138</b>	138,962	4,254	13,922
<b>2017-2018</b>	<b>155,248</b>	138,700	4,095	12,453

2017-2018 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 89.3 хувь нь өдрөөр, 2.6 хувь нь оройгоор, 8.0 хувь нь эчнээ<sup>6</sup>-гээр тус тус сурч байгаа нь өмнөх хичээлийн жилийнхтэй өдрөөр суралцагчдын нийт суралцагчид эзлэх хувь 0.9 пунктээр өссөн бол, оройгоор суралцагч 0.1, эчнээгээр суралцагч 0.9 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Тоогоор нь авч үзвэл нийт суралцагчид 1,890-ээр, үүнээс өдрөөр суралцагчид 262-оор, оройгоор суралцагчид 159-өөр, эчнээгээр суралцагчид 1,469-өөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. (Хүснэгт 8).

Хүснэгт 9. Суралцагчдын тоо (боловсролын зэргээр)

<b>Суралцагчид (боловсролын зэргээр)</b>					
	Бүгд	Дипломын дээд	Бакалавр	Магистр	Доктор
<b>2013-2014</b>	<b>174,075</b>	-	152,708	18,063	3,304
<b>2014-2015</b>	<b>178,295</b>	-	155,839	19,065	3,391
<b>2015-2016</b>	<b>162,626</b>	-	140,296	19,005	3,325
<b>2016-2017</b>	<b>157,138</b>	-	133,223	20,066	3,849
<b>2017-2018</b>	<b>155,248</b>	124	130,484	20,345	4,295

2017-2018 оны хичээлийн жилд нийт суралцагчдын тоо 1,890-ээр буурсан бөгөөд бакалавр<sup>7</sup>-ын зэргээр суралцагчид 2,739-өөр буурч, магистрантурт суралцагчдын тоо 279-өөр, докторантурт суралцагчдын тоо 446-аар тус тус нэмэгдсэн байна. Дээрх бууралт нь үндсэндээ бакалавр (-2,739), тэр тусмаа сургалтын хэлбэрээр нь авч үзвэл бакалаврын өдрийн анги (-1,651) дээр гарчээ. Энэхүү бууралт нь дээд сургуулийн тоо буурсантай холбоотой юм.

Энэ хичээлийн жил шинээр дипломын дээдэд суралцаж байгаа оюутны тоо шинээр нэмэгдсэн нь онцлогтой юм. Эдгээр суралцагчид нь Монгол Коосэн технологийн коллеж, Шинэ монгол технологийн коллежид тус тус суралцаж байна.

Хүснэгт 10. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид (боловсролын зэрэг, сургалтын хэлбэрээр)

	<b>2016-2017</b>				<b>2017-2018</b>			
	Нийт	өдөр	орой	эчнээ	Нийт	өдөр	орой	эчнээ
<b>Бүгд</b>	<b>157,138</b>	<b>138,962</b>	<b>4,254</b>	<b>13,922</b>	<b>155,248</b>	<b>138,700</b>	<b>4,095</b>	<b>12,453</b>
<b>Хувь, %</b>	<b>100.0</b>	<b>88.4</b>	<b>2.7</b>	<b>8.9</b>	<b>100.0</b>	<b>89.3</b>	<b>2.6</b>	<b>8.0</b>
<b>ДИПЛОМЫН</b>	-	-	-	-	124	124	-	-

<sup>6</sup>Эчнээ хөтөлбөрт экстернат орсон болно.

<sup>7</sup>"Дээд боловсролын тухай хууль"-ийн 3.3-д "Дээд боловсролын зэрэг нь багц цагаар хэмжигдэх дипломын, бакалаврын, магистрын, докторын шатлалтай байна" гэж заасан. УИХ-аар 2009 онд "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга батлагдаж гарсан, БСШУ-ны сайдын 2010 оны 235-р тушаалаар "Их, дээд сургууль, техникийн болон мэргэжлийн сургуулиудаар бэлтгэж байгаа мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн индекс"-ийг шинэчлэн тогтоосноор дээд боловсролын сургалтын байгууллагуудад дипломын зэргийн сургалтаар элсэлт авахыг 2010-2011 оны хичээлийн жилээс зогсоосон.

дээд									
Хувь, %	-	-	-	-	100.0	100.0	-	-	
бакалавр	133,223	119,147	4,180	9,896	130,484	117,496	4,035	8,953	
Хувь, %	100.0	89.4	3.1	7.4	100.0	90.0	3.1	6.9	
магистр	20,066	16,722	74	3,270	20,345	17,639	60	2,592	
Хувь, %	100.0	83.3	0.4	16.3	100.0	86.9	0.3	12.8	
доктор	3,849	3,093	-	756	4,295	3,387	-	908	
Хувь, %	100.0	80.4	-	19.6	100.0	78.9	-	21.1	

2017-2018 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 0.1 хувь нь дипломын дээдээр, 84.0 хувь нь бакалаврын, 13.1 хувь нь магистрын, 2.8 хувь нь докторын зэргийн сургалтад хамрагдаж байна. Үүнийг өнгөрсөн хичээлийн жилийн хувьтай харьцуулж үзвэл дипломын дээд зэргийнх шинээр нэмэгдэж +0.1 хувь, бакалаврын зэргийнх -0.8 пунктээр доошилж, магистрантурынх +0.3, докторантурынх +0.4 пунктээр дээшилжээ.

Дипломын дээд, бакалавр, магистрантур, докторантурын сургалтын үндсэн хэлбэр нь өдрийн анги бөгөөд дипломын дээд зэргээр суралцагчид бүгд өдрөөр, бакалаврын зэргээр суралцагчдын 90.0 хувь, магистрантурт суралцагчдын 86.9 хувь, докторантурт суралцагчдын 78.9 хувь нь энэ хэлбэрт хамаарч байна. Энэ нь өмнөх оноос дипломын дээд шинээр нэмэгдсэн, бакалаврт суралцагчид +0.6 пунктээр, магистрантурт суралцагчид +3.6 пунктээр тус тус өссөн бол, докторантурт суралцагчид -1.5 пунктээр буурсан байна. Харин оройн ангийн суралцагчдын хувь бакалаврт 3.1, магистрантурт 0.3, докторантурт оройн ангигүй байгаа бол эчнээ ангийн суралцагчдын хувь бакалаврт 6.9, магистрантурт 12.8, докторантурт 21.1 тус тус байна.

### 2.3. Суралцагчдын хүйсийн харьцаа

Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын 90,094 буюу 58.0 хувийг эмэгтэй, 42.0 хувийг эрэгтэй суралцагч бүрдүүлж, хүйсийн ялгааны индекс 1.38 байна. Энэ нь өөрөөр хэлбэл 100 эрэгтэй суралцагчид 138 эмэгтэй ногдож байна гэсэн үг бөгөөд дээрх үзүүлэлт өнгөрсөн оны түвшингээс 0.01-ээр буурсан байна.

Хүснэгт 11. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид (хүйс, боловсролын зэргээр)

	дипломын дээд	бакалавр	магистр	доктор
эрэгтэй	83.1%	42.6%	37.6%	42.0%
эмэгтэй	16.9%	57.4%	62.4%	58.0%

Боловсролын бүхий л зэргээр суралцагчдын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь давамгайлж байгаагаас магистрантурт суралцагч эмэгтэйчүүдийн эзлэх хувь бакалавр болон докторантурт суралцагчдынхаас арай илүү өндөр байна.

Хүснэгт 12. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын хүйсийн харьцаа (сүүлийн 5 хичээлийн жилээр)

Суралцагчид (хүйсээр, хүйсийн индекс)					
	Бүгд	Эмэгтэй суралцагч	Эрэгтэй суралцагч	Хүйсийн ялгааны индекс	Нийт дүнд эмэгтэйчүүд эзлэх хувь /%/
2013-2014	174,075	101,783	72,292	1.41	58.5
2014-2015	178,295	102,520	75,775	1.35	57.5
2015-2016	162,626	93,674	68,952	1.36	57.6

<b>2016-2017</b>	<b>157,138</b>	91,526	65,612	1.39	58.2
<b>2017-2018</b>	<b>155,248</b>	90,094	65,154	1.38	58.0

Дээд боловсрол эзэмшигчдийн хувьд эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа сүүлийн жилүүдэд нэг түвшинд **(1.4)** тогтворжих хандлагатай нь сүүлийн 5 жилийн статистикаас харагдаж байна.

#### **2.4. Суралцагчдын мэргэжлийн чиглэл<sup>8</sup>**

2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн бакалавр, магистрантур, докторантурт шинээр элсэгчдийн мэргэжлийн чиглэл, индексийг тодорхойлохдоо Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78 болон А/370 дугаар тушаалуудаар батлагдсан мэргэжлийн /хөтөлбөр/чиглэл, индексийг, 2014-2015 оны хичээлийн жилээс өмнө элсэн суралцаж буй суралцагчдын хувьд тэдгээрийг төгстөл нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн тогтоох тухай” 2010 оны 235 дугаар тушаалын дагуу тухайн сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд заасан мэргэжлийн /хөтөлбөр/ чиглэл, индексийг мөрдөхөөр болсон.

Шинэчлэн батлагдсан мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/, индекст хуучныг дүйцүүлэн багцалж авч үзвэл: нийт суралцагчдын 13.2 хувь нь боловсрол; 8.2 хувь нь урлаг ба хүмүүнлэг; 5.8 хувь нь нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй; 26.0 хувь нь бизнес, удирдлага, эрх зүй; 3.9 хувь нь байгалийн шинжлэх ухаан, математик, статистик; 2.3 хувь нь мэдээлэл, харилцаа холбооны технологи; 16.5 хувь нь инженерчилэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт; 2.2 хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй; 13.3 хувь нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал; 3.6 хувь нь үйлчилгээ; 4.7 хувь нь бусад чиглэл (**дээрх салбаруудад одоогоор хамааруулах боломжгүй**)-ээр тус тус суралцаж байна.

Эдгээр үзүүлэлт нь өмнөх оны түвшингээс урлаг, хүмүүнлэгийн эзлэх хувь 0.7, нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн эзлэх хувь 0.6, байгалийн шинжлэх ухаан, математик, статистикийн эзлэх хувь 0.3, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын эзлэх хувь 1.5 пунктээр тус тус өссөн бол боловсролын чиглэлийн эзлэх хувь 0.8, бизнес, удирдлага, эрх зүй 0.7, мэдээлэл, харилцаа холбооны технологи 0.4, инженерчилэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт 1.1, хөдөө аж ахуй, ой, засагны аж ахуй, мал эмнэл зүй 0.4, үйлчилгээ 0.4 пунктээр тус тус буурсан байна.

Боловсролын олон улсын шинэчилсэн стандарт ангиллаар боловсролын салбарын мэргэжлийн чиглэлийг хуучин 8 бүлэгт хуваан ангилж байсныг илүү нарийвчлан 10 бүлэгтэй болгосон. Тухайлбал хуучнаар Нийгмийн шинжлэх ухааны бүлэгт орж байсан “Бизнес, удирдлага, эрх зүй”-г салгаж тусгай бүлэг болгосны дээр мөн Байгалийн шинжлэх ухааны бүлэгт байсан “Компьютерийн ухаан”-ыг Техник, технологийн бүлэгт байсан “Мэдээлэл, холбооны технологи ба систем”-тэй нийлүүлэн “Мэдээлэл, харилцаа холбооны технологи” гэсэн шинэ бүлэг нэмж гаргасан юм.

Хүснэгт 13. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын мэргэжлийн чиглэлийн эзлэх хувь (сүүлийн 5 жилээр)

Мэргэжлийн чиглэл(хөтөлбөр)-ийн нэр	Нийт суралцагчдад тухайн мэргэжлийн чиглэлийн эзлэх хувь (%)				
	2013	2014	2015	2016	2017

<sup>8</sup>Суралцагчдын мэргэжлийн чиглэлийг тодорхойлохдоо ЮНЕСКО-гоос батлан гаргаж, өөрийн гишүүн орнууддаа зөвлөмж болгосон “Боловсролын олон улсын стандарт ангилал”-ыг (1997 оны болон 2011 онд шинэчлэгдсэн) үндсэндээ баримталж байна.

01.Боловсрол	12.6	12.7	13.6	14.0	13.2
02.Урлаг, хүмүүнлэг	7.1	7.1	7.1	7.5	8.2
03. Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	7.5	7.0	6.3	5.2	5.8
04. Бизнес, удирдлага, эрх зүй	27.0	26.1	26.7	26.7	26.0
05. Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	3.8	4.6	4.1	3.6	3.9
06. Мэдээлэл, харилцаа холбооны технологи	2.8	2.8	2.7	2.7	2.3
07. Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт	19.5	18.6	19.0	17.3	16.5
08. Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй	3.3	2.9	2.7	2.6	2.2
09. Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	11.0	11.6	11.8	11.8	13.3
10. Үйлчилгээ	5.1	4.0	4.0	4.0	3.6
11. Бусад	0.3	2.6	1.9	4.6	4.7
<b>Нийт дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Сүүлийн 5 жилийн статистикийн мэдээнээс үзэхэд: нийт суралцагчдын тоо буурсан төдийгүй, урлаг, хүмүүнлэг, эрүүл мэнд-нийгмийн хамгааллын чиглэлээс бусад бүх салбар буурсан байна.

Харин “Бусад” салбарын эзлэх хувь (“Үйлчилгээ”-ний бүлгийг хасаад) 2013 онд 0.3 хувь, 2014 онд 2.6 хувь; 2015 онд 1.9, 2016 онд 4.6, 2017 онд 4.7 хувь хүртлээ өссөн нь МУИС 2014-2015 оны хичээлийн жилээс бакалаврын өдрийн ангийн шинээр элсэгчдийг мэргэжлийн сонголтгүй ерөнхий суурь хөтөлбөрөөр багцалж авч байгаатай холбоотой юм.

2017-2018 оны хичээлийн жилийн суралцагчдын мэргэжлийн чиглэлийг боловсролын зэргээр авч үзвэл: бакалаврын зэргээр суралцагчдын хувьд нийт суралцагчдын мэргэжлийн чиглэлийн хандлагатай ойролцоо байгаа бол магистрантурт суралцагчдын **(35.3)** хувийг бизнес, удирдлага, эрх зүйн мэргэжлээр суралцагчид эзэлж байгаа нь өмнөх оноос 3.3 пунктээр буурсан байна.

Докторантурт суралцагчдын 12.2 хувийг урлаг, хүмүүнлэг; 9.8 хувийг нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй; 21.0 хувийг бизнес, удирдлага, эрх зүйн мэргэжлээр суралцагчид бүрдүүлж байгаа нь өмнөх оноос урлаг, хүмүүнлэгийн салбар 2.6, нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй 0.9 пунктээр тус тус өссөн бол бизнес, удирдлага, эрх зүйн мэргэжлээр суралцагчид 1.1 пунктээр буурсан байна.

Докторантурт байгалийн шинжлэх ухаанаар суралцагчдын хувь **(10.8)** байгаа нь бакалаврт суралцагчдынхаас бараг 3.1 дахин, магистрантурт суралцагчдынхаас 2.1 дахин илүү байна. Өмнөх жил энэ харьцаа бакалаврт 2.6, магистрантурт 1.6 байсан байна.

Өмнөх онд магистрантур, докторантурт суралцагчдын хувьд инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн эзлэх хувь доогуур **(7.8; 7.4)** бакалаврт эзлэх хувь **(19.1)**-иас энэ онд буурч **(7.5; 7.1)** бакалаврт эзлэх хувь **(18.2)** байна.

## **2.5. Суралцагчдын орон нутгийн харьяалал**

Нийт суралцагчдын 44.8 хувь буюу 69,549 нь Улаанбаатар хотын харьяалалтай, үүнээс бакалавраар суралцагчдын хувьд энэ үзүүлэлт 41.1, магистрантурт суралцагчдад 57.8- 61.9, докторантурт суралцагчдад 70.1-73.9 хувьтай байна. Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад Улаанбаатар хотын харьяалалтай суралцагчдын тоо 36-аар өсч, нийт суралцагчдын дүнд эзлэх хувь нь 0.6 пунктээр өссөн байна. Бакалаврын түвшинд суралцаж буй оюутны хувь 0.3 пунктээр буурсан бол магистрантурт суралцагчдын эзлэх хувь 4.1, докторын түвшинд суралцагчдын эзлэх хувь 3.8 пунктээр тус тус өссөн нь хөдөө орон нутгаас бакалаврын зэргээр суралцагчид нэмэгдсэнийг харуулж байна.

Нийт суралцагчдын 55.2 хувь буюу 85,699 нь орон нутгийн харьяалалтайгаас хамгийн их нь Дархан-Уул 7,285 (4.7%), Архангай 6,474 (4.2%), Хөвсгөл 5,712 (3.7%), хамгийн бага нь Говьсүмбэр 1,139 (0.7%), Сүхбаатар 3,810 (2.5%), Дорноговь 2,540 (1.6%), Дундговь 2,365 (1.5%) аймгийн харьяалалтай.

Бүс нутгаар авч үзвэл: Улаанбаатарт хамгийн их буюу 69,549 (44.8%), Хангайн бүсэд 29,466 (19.0%), Төвийн бүсэд 25,281 (16.3%), Баруун бүсэд 21,232 (13.7%), Зүүн бүсэд 9,720 (6.3%) суралцагч тус тус ногдож байна.

Өмнөх жилүүдтэй харьцуулахад энэ хичээлийн жилд нийт суралцагчдын тоо буурснаас шалтгаалан Баруун, Хангай бүсийн суралцагчдын тоо багасч, Улаанбаатар, Төв, Зүүн бүсийн суралцагчдын тоо өссөн дүн гарч байна.

## 2.6. Суралцагчдын насны ангилал

Нийт суралцагчдын 6.6 хувь нь 18 хүртэлх насны, 69.9 хувь нь 18-24 настай, 12.6 хувь нь 25-29 настай, 10.9 хувь нь 30 ба түүнээс дээш насны хүмүүс байна. Сүүлийн 5 жилийн судалгаанаас харахад: их, дээд сургууль, коллежид сурч байгаа 18 хүртэлх насны хүүхдийн тоо буурч байсан бол 2017-2018 оны хичээлийн жилд өссөн байна. Энэ нь дипломын дээд зэргийн оюутан нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Хүснэгт 14. Суралцагчид (насаар)

Он	Суралцагчдын тоо						
	Бүгд	18 хүртэлх нас	18-24 нас	25-29 нас	30-34 нас	35-39 нас	40 ба түүнээс дээш
2013-2014	174,045	19,110	122,947	19,430	5,925	3,982	2,651
2014-2015	178,295	18,101	124,990	21,080	6,537	4,391	3,196
2015-2016	162,626	11,142	115,040	20,999	7,277	4,562	3,606
2016-2017	157,138	9,109	111,259	20,773	7,622	4,918	3,457
2017-2018	155,248	10,289	108,521	19,579	7,963	4,850	4,046

Өмнөх оныхоос 16 хүртэлх настай суралцагчдын тоо 11-ээр, 16 настай суралцагчдын тоо 78-аар тус тус буурсан бол, 17 настай суралцагчдын тоо 1,269-өөр нэмэгдсэн байна.

## 2.7. Шинээр элсэгчдийн тоо

Дээд боловсролын сургалтын байгууллагад 2017-2018 оны хичээлийн жилд 45,480 суралцагч шинээр элссэний 32,919 буюу 72.4 хувийг тухайн жилд ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг төгсөж бүрэн дунд боловсрол эзэмшигчид, 4.9 хувийг бусад хэлбэрийн сургуулиас, 19.2 хувийг ажиллагчдаас, 3.6 хувийг ажилгүйчүүдээс элсэгчид бүрдүүлж байна. Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад нийт шинээр элсэгчид 4,295-аар, түүний дотор ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг төгсгөгчдөөс элсэгчдийн тоо 5,293-аар өсчээ.

Хүснэгт 15. Дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элсэгчдийн тоо (сүүлийн 5 жилээр)

	Шинээр элсэгч					
	Бүгд	Бакалаврт	Дипломын дээдэд	Тухайн жилд ЕБС-ийн 12-р ангийг төгсгөгчдийн тоо, бүгд	Тухайн жилд 12-р анги төгсөгчдөөс элссэн	ЕБС-ийн 12-р ангийг төгсгөгчдийн дүнд түүнээс бакалаврт шинээр элсэгчдийн эзлэх хувь (%)
2013-2014	47,182	40,927	-	35,010	33,273	82.4
2014-2015	43,834	37,495	-	19,735	30,537	87.2
2015-2016	29,023	23,562	-	36,562	17,828	90.3
2016-2017	41,195	35,429	-	38,525	27,626	75.6
2017-2018	45,480	39,311	66		32,919 <sup>9</sup>	85.4

Бакалаврын сургалтад шинээр элсэгчдийн дотор тухайн жилд 12 дугаар ангийг төгсгөгчдөөс дээд сургуульд элсэгчдийн хувь 2012-2014 онд тогтвортой, дунджаар 81.0 орчим хувьтай байснаа 2015 онд ерөнхий боловсролын сургуулийн 12 жилийн тогтолцооны 12 дугаар ангийн анхны төгсөлт болж бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдийн тоо өмнөх онуудаас бараг 2 дахин багассантай холбоотойгоор элсэлт 90.3 хувь болж өссөн байна. 2016 оноос аажмаар элсэлт өссөн байна.

## 2.8. Дотуур байранд сууж байгаа суралцагчдын тоо

2017-2018 оны хичээлийн жилийн эхний байдлаар 14,841 суралцагч дотуур байранд суухаар хүсэлт гаргасны 96.9 хувь буюу 14,378 нь дотуур байраар хангагджээ. Дотуур байранд амьдарч байгаа суралцагчдын 13,640 (94.9%) нь өөрийн сургуулийн, 738 (5.1%) нь бусад сургуулийн дотуур байранд сууж байна. Дотуур байранд суугчдын тоо өнгөрсөн хичээлийн жилийнхтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал дотуур байранд суухаар саналаа өгсөн суралцагчдын тоо 2,251-ээр, дотуур байранд суугчдын нийт тоо 2,004-өөр өсчээ.

Хүснэгт 16. Дотуур байранд суудаг суралцагчдын тоо (сүүлийн 5 жилээр)

Үзүүлэлт	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018
Дотуур байранд суухаар саналаа өгсөн, бүгд	17,192	14,123	11,740	12,590	14,841
Дотуур байранд сууж байгаа, бүгд	14,229	12,748	11,058	12,374	14,378
Бүгдээс: эмэгтэй	9,687	8,887	7,962	8,904	10,340
Дотуур байрны хангалт	82.8	90.3	94.2	98.3	96.9
Сургуулийнхаа дотуур байранд сууж байгаа, бүгд	12,701	11,865	9,774	11,198	13,640
Сургуулийнхаа дотуур байранд суугчдын дотуур байранд сууж байгаа нийт суралцагчдад эзлэх хувь (%)	89.3	93.1	88.4	90.5	94.9

Дотуур байранд суухаар саналаа өгсөн суралцагчдын тоо 2012-2013 онд 17,000 орчим, дотуур байранд суугчдын тоо 14,000 гаруйд хэлбэлзэж байсан бол 2014 оноос дээрх хоёр үзүүлэлт ерөнхийдөө буурах хандлагатай байна.

<sup>9</sup> Тухайн жилд 12-р анги төгсөөд бакалавр, дипломын дээдэд элссэн суралцагчдын нийлбэр дүн. Дипломын дээдэд 66 хүүхэд тухайн жил 12-р анги төгсөөд элсэн орсон байна.

Улаанбаатар хотод суралцагчдын бараг тэн хагас хувь нь **(47.2% буюу 74,240 суралцагч)** орон нутгийн харьяалалтай байгаагаас үзэхэд дотуур байранд суух сонирхол төдийлэн их биш, гол төлөв гадуур хамаатан садныхаараа юмуу хэсэг бүлгээрээ байр түрээслэн суух хандлага давамгайлж байна.

Дотуур байранд бакалавраар сурч байгаа, өдрийн ангийн оюутнууд сууж байна. Нийт суугчдын 71.9 хувь нь эмэгтэй, 33.6 хувь нь I курс (бэлтгэл ороод), 24.7 хувь нь II курсын оюутнууд, мөн 11,127 буюу 77.4 хувь нь төрийн өмчийн сургуулийн суралцагчид юм.

Дээд боловсролын сургалтын байгууллагуудад 2017 оны эцсийн байдлаар 136.3 мянган м<sup>2</sup> ашигтай талбай бүхий 88 дотуур байр ашиглагдаж байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил байна.<sup>10</sup>

Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагууд үндсэндээ өөрийн эзэмшлийн оюутны дотуур байртай.

### **2.9. Суралцагчдын сургалтын төлбөрийн дундаж хэмжээ**

2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ төрийн өмчийн сургуульд 2,034.1 мянган, төрийн бус өмчийн сургуульд 2,215.3 мянган төгрөг байна. Үүнийг өмнөх хичээлийн жилтэй харьцуулбал: төрийн өмчийн сургуульд сургалтын төлбөр 6.3 хувиар, төрийн бус өмчийн сургуульд 13.5 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 17. Бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ (мянган төгрөг)

Үзүүлэлт	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018
Төрийн өмчийн сургуульд	1,149.8	1,490.1	1,688.0	1,913.0	2,034.1
Төрийн бус өмчийн сургуульд	1,292.3	1,595.1	1,842.3	1,952.2	2,215.3
Төрийн ба төрийн бус өмчийн сургуулийн дундаж	1,221.1	1,542.6	1,765.15	1,932.6	2,124.7
Өмнөх онтой харьцуулсан өсөлтийн хувь (%):					
- Төрийн өмчийн сургуульд	24.8	29.6	13.3	13.3	6.3
- Төрийн бус өмчийн сургуульд	18.1	23.4	15.5	6.0	13.5

Сүүлийн 5 жилийн статистикийн мэдээнээс үзэхэд бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ өмчийн хэлбэрээс үл хамааран жил тутам нэмэгдэж ирсэн байгаа бөгөөд 2017 онд 2013 оныхоос төрийн өмчийн сургуульд 1.8, төрийн бус өмчийн сургуульд 1.7 дахин өссөн байна. Сургалтын төлбөрийн хэмжээ төрийн бус өмчийн сургуульд төрийн өмчийнхөөс арай өндөр байна. Сургалтын төлбөрийн хэмжээ боловсролын зэрэг, сургалтын хэлбэрээсээ хамаарч өөр өөр байгаа бөгөөд тухайлбал: магистрантур, докторантурт суралцагчдын сургалтын төлбөр бакалаврын сургалтынхаас харьцангуй өндөр байна.

### **2.10. Суралцагчдын тоог сургуулиудаар бүлэглэсэн байдал**

<sup>10</sup>Улсын төсвийн хөрөнгөөр Хууль сахиулахын их сургуулийн 850 сонсогчийн дотуур байр шинээр ашиглалтад орсон, 1000 оюутны багтаамж бүхий "Оюутны өргөө" 1, 2 дугаар байр бүрэн хүч чадлаараа үйл ажиллагаагаа эхлэн МУБИС-ийн харьяалалд шилжсэн.

Их, дээд сургууль, коллежийн суралцагчдын тоог бүлэглэн харуулав.

Хүснэгт 18. Суралцагчдын тоог бүлэглэсэн байдал (сургуулийн өмчийн хэлбэрээр)

Суралцагчдын тооны бүлэг	Төрийн өмчийн		Төрийн бус өмчийн		Гадаадын салбар		Бүгд	
	Сургууль	Суралцагч	Сургууль	Суралцагч	Сургууль	Суралцагч	Сургууль	Суралцагч
100 хүртэл суралцагчтай			11	412	3	147	14	559
101-200 суралцагчтай	3	306	11	1,524	-	-	14	1,830
201-300 суралцагчтай	2	492	12	2,748	-	-	14	3,240
301-400 суралцагчтай	-	-	5	1,718	-	-	5	1,718
401-700 суралцагчтай	3	1,928	14	7,450	-	-	17	9,378
701-1,000 суралцагчтай	1	842	7	5,846	-	-	8	6,688
1,001-2,000 суралцагчтай	-	-	7	9,698	-	-	7	9,698
2,001-5,000 суралцагчтай	4	12,595	6	22,063	-	-	10	34,658
5,001-10,000 суралцагчтай	1	9,749	2	14,169	-	-	3	23,918
10,001-20,000 суралцагчтай	3	42,609	-	-	-	-	3	42,609
20,001-ээс дээш	1	20,952	-	-	-	-	1	20,952
<b>Бүгд</b>	<b>18</b>	<b>89,473</b>	<b>75</b>	<b>65,628</b>	<b>3</b>	<b>147</b>	<b>96</b>	<b>155,248</b>

100 хүртэл суралцагчтай 14; 200 хүртэл суралцагчтай 14 сургууль байгаа нь нийт сургуулийн 29.2 хувь, нийт суралцагчдын 1.5 хувь (**тэдгээрт нийт 2,389 суралцагч сурч байгаа**)-ийг эзэлж байна. Дээрх сургуулиудын 11 төрийн бус өмчийн, 3 нь гадаадын салбар сургууль юм.

Харин 5,000-10,000 суралцагчтай 3; 10,000-аас дээш суралцагчтай 3 сургууль, 20,000-аас дээш суралцагчтай сургууль 1 байгаа нь нийт сургуулийн 7.3 хувь, суралцагчдын 56.3 хувь (**87,479 суралцагч**)-ийг эзэлж байна. Эдгээр 7 сургуулийн 5 нь төрийн өмчийн их сургууль байгаа нь нийт суралцагчдын дийлэнх хэсэг цөөн тооны сургуульд, тэр тусмаа төрийн өмчийн их сургуулиудад төвлөрч байгааг харуулж байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад 200 хүртэлх суралцагчтай сургуулийн тоо 4-өөр, эзлэх хувь нь 3.9 пунктээр тус тус өссөн бол 5,000-аас дээш суралцагчтай сургуулийн тоо 1-ээр, эзлэх хувь 1 пунктээр тус тус өсчээ.

2017-2018 оны хичээлийн жилд төрийн бус өмчийн сургуулиас Монгол дээд сургууль, Дизайн урлагийн коллеж, Этүгэн их сургуулийн Дархан-уул аймаг дахь салбар сургууль бакалаврын өдрийн ангидаа шинээр элсэлт аваагүй байна. Түүнчлэн төрийн бус өмчийн 5 сургууль бакалаврын өдрийн ангидаа 20 хүртэл шинээр элсэгчтэй байна.

Хамгийн их суралцагчтай төрийн өмчийн сургууль нь МУИС (**20,952-орон нутаг дахь салбар сургуулиуд ороод**) болж ШУТИС (**18,968-орон нутаг дахь салбар сургуулиуд ороод**)-тай ойролцоо байгаа бол төрийн бус өмчийн сургуулиас Монголын үндэсний их сургууль (**8,868**) хэвээр байна. Түүнчлэн хамгийн цөөн суралцагчтай төрийн өмчийн сургууль нь 2013 онд шинээр байгуулагдсан Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль (**128**), төрийн бус өмчийн сургуулиас Сутай дээд сургууль (5), энэ онд шинээр байгуулагдсан Зүүн хүрээ коллеж (10), Монгол дахь Америкийн их сургууль (12), Их монгол дээд сургууль (14), Гүрэн дээд сургууль(15), гадаадын салбар сургуулиас Эрхүүгийн Зам харилцааны улсын их сургуулийн Улаанбаатар хот дахь салбар сургууль (21) байна.

### 3. Дээд боловсролын сургалтын байгууллагад гадаадын иргэдээс суралцагчид

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагад 2017-2018 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр гадаадын 31 орны 1,636 иргэн сурч байгаагийн 1,066 (**65.2%**) нь бакалаврын (**МОНГОЛ ХЭЛНИЙ БЭЛТГЭЛ ОРООД**), 420 (**25.7%**) нь магистрын, 150 (**9.2%**) нь докторын сургалтын хөтөлбөрт хамрагдаж байна. Эдгээр суралцагчдын 75 (**4.6%**) нь хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр, 1,443 (**88.2%**) нь хувийн, үлдсэн нь 118 (**7.2%**) бусад зардлаар суралцаж байна. Гадаадын иргэдээс суралцагчдын тоо өмнөх хичээлийн жилийнхээс 116-аар буюу 7.6 хувиар өссөний дотор бакалаврын суралцагчдын тоо 216-аар нэмэгдсэн бол магистрантурт суралцагчдын тоо 77-оор, докторантурт суралцагчдын тоо 23-аар тус тус буурсан байна.

Гадаадын суралцагчдын 52.6 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оноос 4.8 пунктээр өссөн байна. Нийт суралцагчдын 77.6 хувь нь (**1,269**) төрийн өмчийн, 17.2 хувь нь (282) төрийн бус өмчийн, 5.2 хувь нь (**85**) гадаадын салбар сургуулиудад сурдаг. Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулбал төрийн өмчийн сургуульд суралцагчдын тоо 146 буюу 3.7 пунктээр нэмэгдсэн бол, төрийн бус өмчийнх 30-аар буюу 3.3 пунктээр, гадаадын салбар сургуулийн суралцагчдын тоо хэвээр боловч нийтэд эзлэх хувь 0.4 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн өмчийн 10, төрийн бус өмчийн 25, гадаадын салбар сургууль 3, нийтдээ дээд боловсролын сургалтын 38 байгууллагад гадаадын оюутан, магистрант, докторант сурч байгаагаас 15 сургууль (**39.5 хувь**) нь 6-гаас доош суралцагчтай байгаа нь өмнөх жилээс 2-оор буюу 5.2 пунктээр буурсан байна.

Гадаадаас суралцагч хамгийн олон суралцагчтай сургуульд: төрийн өмчийн сургуулиас Монгол Улсын их сургууль 450, төрийн бус өмчийн сургуулиас Эм Ай Ю дээд сургууль 118, гадаадын салбар сургуулиас ОХУ-ын Дорнод Сибирийн Технологи, удирдлагын их сургуулийн Улаанбаатар хот дахь салбар 41 суралцагчтай байна. Өнгөрсөн онд дээд боловсролын сургалтын 38 байгууллага гадаадын суралцагчтай байсан бол энэ онд хэвээр байна.

БНХАУ-аас 1,118, ОХУ-аас 180, БНСУ-аас 135 суралцагч байгаа нь нийт гадаадын суралцагчдын 87.6 хувь болж байна. Эдгээр 3 улсаас суралцагчдын хувь өнгөрсөн хичээлийн жилийнхээс 3.2 пунктээр өссөний дээр тооны хувьд БНХАУ-ын суралцагчид 149-өөр, БНСУ-ын суралцагчид 3-аар нэмэгдэж, харин ОХУ-аас суралцагчид 2-оор багасжээ. 1-8 суралцагчтай гадаадын 20 улс байгаа нь өмнөх оноос 1-ээр буурсан байна.

Хүснэгт 19. Дээд боловсролын сургалтын байгууллагад гадаадаас суралцагчдын тоо (сүүлийн 5 жилээр)

Үзүүлэлт	2013- 2014	2014- 2015	2015- 2016	2016- 2017	2017- 2018
Гадаадын суралцагчдын улсын тоо	30	32	27	32	31
Гадаадын суралцагчтай сургуулийн тоо	40	39	46	38	38
Гадаадын суралцагчдын тоо, бүгд	1,130	1,245	1,450	1,520	1,636
Бүгдээс: - БНХАУ-аас суралцагчдын тоо	449	561	837	969	1,118
- ОХУ-аас суралцагчдын тоо	250	254	206	182	180
- БНСУ-аас суралцагчдын тоо	203	176	137	132	135
Бүгдээс: - Магистрантурт суралцагчдын тоо	209	258	368	497	420
- Магистрантурт суралцагчдын хувь (%)	<b>18.5</b>	<b>20.7</b>	<b>25.4</b>	<b>32.7</b>	<b>25.7</b>
Бүгдээс: - Докторантурт суралцагчдын тоо	103	114	138	173	150
- Докторантурт суралцагчдын хувь (%)	<b>9.1</b>	<b>9.2</b>	<b>9.5</b>	<b>11.4</b>	<b>9.2</b>

Сүүлийн 5 жилийн статистик мэдээгээр гадаадаас суралцагчдын тоо өсөж байгаагийн дотор магистрантур, докторантурт суралцагчдын тоо нэмэгдэх хандлагатай байна. Ялангуяа БНХАУ-аас суралцагчдын тоо сүүлийн 5 жилд 2.5 дахин нэмэгджээ. Харин ОХУ, БНСУ-аас суралцагчдын тоо буурсан үзүүлэлттэй байна.

#### 4. Дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажиллагчид

**4.1. Нийт ажиллагчдын тоо.** Дээд боловсролын сургалтын байгууллагуудад нийт 12,705 хүн ажиллаж байгаагийн 62.2 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд өнгөрсөн хичээлийн жилийн мөн үетэй харьцуулахад ажиллагчдын тоо 35 хүнээр (-0.3%) цөөрсөнөөс төрийн өмчийн сургуульд 130-аар буурсан бол, төрийн бус өмчийн сургуульд 95 хүнээр нэмэгдсэн байна. Нийт ажиллагчдын 8,151 нь (64.2%) төрийн өмчид ажиллаж байгаа нь нийт дүнд эзлэх хувиараа өмнөх оноос 0.8 пунктээр буурсан бол, 4,554 нь (35.8%) төрийн бус өмчид ажиллаж байгаа нь 0.8 пунктээр өссөн байна.

Хүснэгт 20. Ажиллагчдын тоо (өмчийн хэлбэр, байршлаар)

Хичээлийн жил	Ажиллагчдын тоо	Өмчийн хэлбэр		Байршил	
		Төрийн өмч	Хувийн өмч <sup>11</sup>	Хот	Хөдөө
2013-2014	13,212	8,534	4,678	11,436	1,776
2014-2015	13,360	8,547	4,813	11,614	1,746
2015-2016	13,057	8,456	4,601	11,351	1,706
2016-2017	12,740	8,281	4,459	11,156	1,584
2017-2018	12,705	8,151	4,554	11,138	1,567

**4.2. Үндсэн багшийн тоо.** Нийт ажиллагчдын 6,724 нь (52.9%) үндсэн багш юм. Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад үндсэн багшийн тоо 193-аар, түүний дотор төрийн өмчийн сургуульд 213, гадаадын салбар сургуульд 3-аар тус тус буурсан бол, хувийн өмчийн сургуульд 23-аар нэмэгдсэн байна. Нийт үндсэн багшийн 62.9 хувь нь төрийн өмчийн, 36.8 хувь нь хувийн өмчийн, 0.2 хувь нь гадаадын салбар сургуульд багшилж байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс төрийн өмчийн сургуульд ажиллаж байгаа багшийн тоо 1.3 пунктээр, гадаадын салбар сургуульд ажиллаж байгаа багшийн тоо 0.1 пунктээр тус тус буурсан бол хувийн өмчийн сургуульд ажиллаж байгаа багшийн тоо 1.3 пунктээр өссөн байна. Суралцагчдын тоо багассан нь үндсэн багшийн тоо буурахад нөлөөлсөн байх талтай.

Хүснэгт 21. Их, дээд сургуулийн үндсэн багш

	Их, дээд сургуулийн үндсэн багш			
	Нийт	Төрийн	Хувийн	Гадаадын салбар
2013-2014	7,385	4,675	2,664	46
2014-2015	7,528	4,779	2,711	38
2015-2016	7,121	4,578	2,517	26
2016-2017	6,917	4,444	2,454	19
2017-2018	6,724	4,231	2,477	16

Нийт үндсэн багшийн 1,949 нь (29.0%) докторын зэрэгтэй, 4,331 нь (64.4%) магистрын зэрэгтэй байна. Цагийн багш 1,295 байгаа нь өмнөх оноос 139-өөр буурсан байна.

Нийт үндсэн багшийн 6.9 хувь нь дадлагажигч<sup>12</sup> багш, 41.7 хувь нь багш, 29.6 хувь нь ахлах багш, 12.2 хувь нь дэд профессор, 9.6 хувь нь профессор багш байна. Үүнийг өмнөх

<sup>11</sup> Хувийн өмчийн сургуулийн тоонд гадаадын салбар сургуулийн тоог оруулсан болно.

онтой харьцуулахад дадлагажигч багшийн эзлэх хувь 0.4, профессор багшийн эзлэх хувь 0.1 пунктээр тус тус багасч, багшийн эзлэх хувь 0.1, ахлах багш 0.1, дэд профессор багшийн эзлэх хувь 0.2 пунктээр тус тус өсчээ.

Хүснэгт 22. Багш нарын нас (насны ангилалаар)

	30 хүртэл	30-50	51-55	56-59	60 ба түүнээс дээш
<b>2013-2014</b>	2,025	3,812	677	317	554
<b>2014-2015</b>	1,897	4,029	664	347	591
<b>2015-2016</b>	1,508	4,043	660	372	538
<b>2016-2017</b>	1,363	3,943	728	363	520
<b>2017-2018</b>	1,234	3,997	685	342	471

Насны хувьд нийт үндсэн багшийн 18.3 хувь нь 30 хүртэлх насны залуучууд, 14.3 хувь нь 55-аас дээш насны ахмад багш нар бөгөөд тэдгээрээс 471 нь тэтгэврээ тогтоолгоод ажиллаж байна.

Улсад ажилласан жилээр нь ангилж үзвэл: 18.8 хувь нь 1-5 жил, 15.7 хувь нь 25-аас дээш жил ажилласан ажлын дадлага туршлагатай хүмүүс байна. Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад 30 хүртэлх насны болон 1-5 жил ажилласан хүний эзлэх хувь 1.4 ба 0.9 пунктээр, 55-аас дээш насны хүний эзлэх хувь 1.0 пунктээр тус тус буурсан байна.

**5. Дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсгөгчид**

**5.1. Төгсөгчдийн тоо, боловсролын зэрэг.** 2016-2017 оны хичээлийн жилд 34,681 суралцагч сургуулиа төгссөн нь өмнөх хичээлийн жилийнхээс 1,208-аар буюу 3.5 хувиар бага, 2012-2013 оны хичээлийн жилийнхээс 9,562-оор буюу 7.4 хувиар бага байна.

Хүснэгт 23. Төгсөгчид(боловсролын зэргээр)

	Төгсөгчид	Дипломын дээд	Бакалавр	Магистр	Доктор
<b>2012-2013</b>	<b>37,243</b>	1,181	32,234	3,697	131
<b>2013-2014</b>	<b>33,850</b>	259	29,477	3,996	118
<b>2014-2015</b>	<b>35,181</b>	93	29,728	5,254	106
<b>2015-2016</b>	<b>35,889</b>	231	30,663	4,859	136
<b>2016-2017</b>	<b>34,681</b>	495	30,301	3,772	113

Нийт төгсөгчдийн 495 нь дипломын дээд (1.4%), 30,301 нь бакалаврын (87.4%), 3,772 нь магистрын (10.9%), 113 нь докторын (0.3%) зэргээр төгсжээ. Төгсөгчдийн тооны өсөлт, бууралтыг өнгөрсөн хичээлийн жилийнхтэй харьцуулж боловсролын зэргээр авч үзвэл: дипломын дээд (+264)-аар нэмэгдсэн бол бакалавр (-362), магистр (-1,087), доктор (-23)-аар тус тус буурсан байна.

**5.2. Төгсөгчдийн хүйсийн харьцаа.** Нийт төгсөгчдийн 61.1 хувийг эмэгтэйчүүд, 38.9 хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж, хүйсийн ялгааны индекс 1.57 байна. Энэ нь өөрөөр хэлбэл 100 эрэгтэй төгсөгчид 157 эмэгтэй төгсөгч ногдож байна гэсэн үг. Өмнөх оны төгсөгчдөөс эмэгтэйчүүд +0.2 пунктээр өссөн бол, эрэгтэйчүүд -0.2 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Дээд боловсролын бүх зэргээр төгсөгчдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь давамгайлж байна.

Хүснэгт 24. Дээд боловсролын сургалтын байгууллагыг

<sup>12</sup>Дээд боловсролын тухай хуулийн 13.3-д “Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн албан тушаал нь профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш байна” гэж заасан.

төгсөгчид (хүйс, боловсролын зэргээр)

	дипломын дээд	бакалавр	магистр	доктор
эрэгтэй	26.5%	33.3%	37.1%	45.1%
эмэгтэй	73.5%	60.7%	62.9%	54.9%

Төгсөгчдийн хүйсийн харьцаа зарим мэргэжлийн чиглэлүүдээр эрс ялгаатай байна. Жишээ нь: эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарын төгсөгчдийн 85.0%, боловсролын салбарын төгсөгчдийн 83.0%, нийгмийн халамж, мэдээлэл-сэтгүүл зүй, биологи, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр суралцаж төгсөгчдийн 78.8-81.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол компьютер, тээвэр (төмөр зам), барилга-архитектур, бүх төрлийн инженерийн чиглэлээр төгсөгчдийн 72.9-76.6 хувь, цэрэг, цагдаа, аюулгүй байдлын салбарын төгсөгчдийн 82.1 орчим хувь нь эрэгтэйчүүд байна.

**5.3. Төгсөгчдийн мэргэжлийн чиглэл.** Нийт төгсөгчдийн 15.0% нь боловсрол, 5.8% нь урлаг ба хүмүүнлэг, 36.6% нь нийгэм, эдийн засаг, мэдээлэл-сэтгүүл зүй, бизнес, удирдлага, эрх зүй, 4.0% нь байгалийн шинжлэх ухаан, 17.5% нь инженер, технологи, барилга-архитектур, 2.4% нь хөдөө аж ахуй, 12.6% нь эрүүл мэнд, нийгмийн халамж, 5.0% нь үйлчилгээний, 1.1% нь бусад салбарт хамаарч байна. Үүнийг өмнөх хоёр хичээлийн жилтэй харьцуулбал: инженер, технологи, барилга-архитектурын салбарын эзлэх хувь 12.7-17.5 хүртэл өсөж, бусад салбарын хувь ойролцоо түвшинд байна. Гэхдээ урлаг ба хүмүүнлэг, нийгэм, эдийн засаг, мэдээлэл-сэтгүүл зүй, бизнес, удирдлага, эрх зүйн салбараар төгсөгчдийн нийт дүнд эзлэх хувь 44.3-40.3 буюу зонхилох хэсэг нь хэвээр байна.

**5.4. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал.** 2016-2017 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 32.2 хувь нь төгссөн даруйдаа ажлын байртай болсон гэсэн статистик мэдээ гарлаа. Энэ үзүүлэлт өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад 1.3 пунктээр өсчээ. Докторантур төгсөгчид бараг бүхэлдээ (98.2%), магистрантур төгсөгчдийн 74.8 хувь нь ажлын байртай хүмүүс байгаа бол бакалаврын зэргээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал 26.9 орчим хувьтай байгаа нь нэгдүгээрт, зарим сургуулиуд төгсөгчдийн ажил эрхлэлтийн мэдээгээ бүрэн гаргаж чадахгүй байгаа, хоёрдугаарт, төгсөгчид төгссөн үедээ тэр бүр ажлын байртай болж амжихгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

**6. Дээд боловсролын магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагууд**

**6.1. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагын тоо.** 2017 оны эцсийн байдлаар дээд боловсролын сургалтын 74<sup>13</sup> байгууллагын магадлан итгэмжлэл нь хүчинтэй байгаагаас 69<sup>14</sup> нь их, дээд сургууль, коллеж байна. Магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо 2009 оны эцэст 86, 2010 онд 68, 2011 онд 67, 2012 онд 70, 2013 онд 63<sup>15</sup>, 2014 онд 65, 2015 онд 67, 2016 онд 69 болсон байна.

	Магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо	Ажиллагчдын тоо	Үндсэн багш	Суралцагчдын тоо
<b>2013-2014</b>	63			163,156
<b>2014-2015</b>	65			168,943

<sup>13</sup>Энэ тоонд мэргэжлийн 5 сургууль орсон. Үүнд: Дархан-уул аймаг дахь Уул уурхайн эрчим хүчний политехник коллеж, Үйлдвэрлэл урлалын политехник коллеж, Монгол-Солонгосын политехник коллеж, Завхан аймаг дахь политехник коллеж, Баянхонгор аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв

<sup>14</sup>Мэргэжлийн 4 сургуулийг хассан тоо.

<sup>15</sup>Өмнө нь бие даан магадлан итгэмжлэгдсэн байсан төрийн өмчийн харьяа сургуулиуд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 15 дугаар тогтоолоор төрийн өмчийн их сургуулиудын салбар болон бүрэлдэхүүний сургууль болж өөрчлөгдсөнөөс магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо буурсан байдаг.

2015-2016	67			154,172
2016-2017	69			152,786
2017-2018	69			150,932

Төрийн өмчийн сургуулиудаас Үндэсний тагнуулын академи, Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль магадлан итгэмжлэлд ороогүй байгаа бол төрийн бус өмчийн 21 их сургуулийн 1 (Монгол дахь Америкийн их сургууль) нь, 48 дээд сургуулийн 15 нь, 6 коллежийн 5 (Дизайн урлагийн коллеж, Зүүн хүрээ коллеж, Монголын хүний нөөцийн удирдлагын коллеж, Монгол Коосэн технологийн коллеж, Шинэ монгол технологийн коллеж) нь, гадаадын 3 салбар сургууль бүгд магадлан итгэмжлэгдээгүй байна. Түүнчлэн 2017 онд 32 сургуулийн магадлан итгэмжлэлийн хугацаа дуусахаар байна.

### **6.2. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо.**

Он	Нийт тоо	Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо		
		Бакалавр	Магистр	Доктор
2013	37	35	2	
2014	34	30	3	1
2015	29	28	1	
2016	-	-		
2017	1	1	-	-

2015-2017 онд боловсролын магадлан итгэмжлэлийн ажлын албаны шинэчлэлийн үе буюу хууль эрх зүй, дүрэм журмыг шинэчлэх шаардлагатай гэдэг үндэслэлээр магадлан итгэмжлэх үйл ажиллагаа түр зогссон.

**6.3. Магадлан итгэмжлэгдсэн сургуульд суралцагчдын тоо.** Дээрх магадлан итгэмжлэгдсэн 69 сургуульд 150,932 суралцагч сурч байгаа нь нийт суралцагчдын 97.2 хувийг эзэлж байгаа өмнөх онтой ижил байна. Эдгээрээс 89,345 (**59.2%**) нь төрийн өмчийн, 61,587 (**40.8%**) нь төрийн бус өмчийн сургуульд сурч байгаа нь нийт дүнд эзлэх хувиараа өнгөрсөн оныхоос төрийн өмчийн сургуулийн сурагчдын эзлэх хувь 0.8 пунктээр буурсан бол, төрийн бус өмчийн сургуулийн хүүхдийн эзлэх хувь эсрэгээрээ 0.8 пунктээр өссөн байна. Суралцагчдын тоо буурснаас хамаарч магадлан итгэмжлэгдсэн сургуульд суралцагчдын тоо өнгөрсөн оныхоос 1.8 мянгаар буюу 1.2 хувиар багасчээ.

-----000-----